



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алдархаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/185/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай сум

2024 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: bat-undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Оюунсүвд

Утас: 99076038

Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга
- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
- 4.1 Ерөнхий зүйл.....
- 4.2 Материаллаг байдал.....
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

᠒᠐᠒4.03.᠒᠘ № ᠒᠑8

тантай _____-ны № _____-т

АЛДАРХААН СУМЫН
ЗАСАГ ДАРГА Ю.ДЭЛГЭРНАСАН -д

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Алдархаан сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Алдархаан сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчдын аудитаар илэрсэн алдаа зөрчилд дүн шинжилгээ хийхэд сумын Орон нутгийн хөгжлийн сан болон Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой 250,346.6 мянган төгрөгийн зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.4-т "Сум дүүргийн Засаг даргын чиг үүрэг", 3.4.3-т "Сум, дүүргийн хэмжээнд орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих", Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар батлагдсан "Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.4.3-д "энэ журмын 3.4.2-т заасан төслийг хэрэгжүүлэх хуулийн этгээд, иргэнтэй холбогдох хууль, журмын дагуу зээлийн болон барьцааны гэрээ байгуулж, биелэлтийг хангуулах, төслийн явц, үр дүнд байнгын хяналт тавих", 3.4.11-д "Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ" гэж заасныг зөрчсөн байна.

Audit(D)A4-тоот/2024

᠒᠐᠒4.03.᠒᠘

Асуудлыг онцолсон хэсэг

2023 оны санхүүжилтийг өмнөх онтой харьцуулахад 925,376.4 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь татвар болон татварын бус орлого 124,411.6 мянган төгрөгөөр өссөн, орон нутгийн хөгжлийн сан 171,347.7 мянган төгрөгөөр, тус онд цалин нэмэгдсэнтэй холбогдуулан аймгаас авах санхүүгийн дэмжлэг 147,305.2 мянган төгрөгөөр, татварын орлогын санхүүжилт 188,991.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн, улсын төсөвт байгууллагын тогтмол зардал 258,264.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс олгосон, төвлөрүүлэх шилжүүлэг 35,056.5 мянган төгрөгөөр өссөн зэрэгтэй холбоотой байна.

Аудитын гол асуудал

Алдархаан сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилд дүн шинжилгээ хийхэд сумын Засаг даргын үйл ажиллагаатай шууд хамааралтай алдаа, зөрчил өмнөх оноос 39.6 хувиар өссөн байна.

Бусад асуудлын хэсэг

Алдархаан сумын Засаг дарга нь тайлант онд татварын орлогыг 269,113.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэл 402,033.8 мянган төгрөг буюу 49.4 хувиар давсан байна. Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт 27,012.0 мянган төгрөгийг 33 иргэнд буцаан олгосон байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	699,702.2	915,868.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	446,645.9	667,775.7
33	АВЛАГА	214,658.0	196,679.3
35	БАРАА МАТЕРИАЛ	38,398.3	51,413.7
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	534,670.5	871,619.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	534,670.5	871,619.4
39200	Биет хөрөнгө	504,071.8	841,590.7
39300	Биет бус хөрөнгө	30,598.7	30,028.7
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,234,372.7	1,787,488.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	8,754.3	3,041.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,754.3	3,041.6
41300	Өглөг	8,754.3	3,041.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,225,618.5	1,784,446.5
51	Засгийн газрын хувь оролцоо	1,225,618.5	1,784,446.5
51100	Засгийн газрын оруулсан капитал	449,344.4	449,344.4
51200	Хуримтлагдсан үр дүн	711,516.4	1,270,344.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	64,757.7	64,757.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,234,372.7	1,787,488.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,235,152.6	1,774,368.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	259,753.3	356,679.4
110	Орлогын албан татвар	163,793.4	174,647.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	177,340.4	201,659.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-13,546.9	-27,012.0
113	Хөрөнгийн албан татвар	3,768.7	73,876.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	92,191.2	108,154.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,608.7	425,596.2
120	Нийтлэг татварын бус орлого	15,608.7	425,596.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	959,790.5	992,092.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	980,364.6	936,317.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	980,364.6	936,317.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	527,736.9	918,158.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	239,237.0	402,383.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,980.4	53,446.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,445.7	37,832.9
2104	Хангамж, бараа материалын зардал	24,556.6	42,827.5
2105	Нормативт зардал	189.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,977.4	3,423.6
2107	Томилот, зочны зардал	2,187.0	7,682.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,732.6	4,538.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	188,431.2	366,023.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	452,627.7	18,159.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	254,787.9	838,050.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,372,368.6	279,222.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-3,117,580.6	558,828.0

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,368,201.9	4,368,201.9
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,225,618.5	1,225,618.5
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,343,199.1	4,343,199.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-25,002.8	-25,002.8
9	Тайлант үеийн үр дүн	-3,117,580.6	-3,117,580.6
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,225,618.5	1,225,618.5
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,784,446.5	1,784,446.5
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,225,618.5	1,225,618.5
19	Тайлант үеийн үр дүн	558,828.0	558,828.0

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,251,774.0	1,391,327.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	259,753.3	356,679.4
110	Орлогын албан татвар	163,793.4	174,647.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	177,340.4	201,659.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-13,546.9	-27,012.0
113	Хөрөнгийн албан татвар	3,768.7	73,876.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	92,191.2	108,154.7
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	7,707.9	6,671.8
1181	Газрын төлбөр	22,290.7	73,468.7
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	62,192.6	28,014.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	32,230.2	42,555.9
120	Нийтлэг татварын бус орлого	32,230.2	42,555.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	959,790.5	992,092.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	929,437.7	884,122.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	929,437.7	884,122.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	475,913.5	865,963.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	237,051.0	405,601.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,063.0	55,132.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,029.8	38,032.9
2104	Хангамж, бараа материалын зардал	23,778.7	38,970.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,828.3	4,789.8
2107	Томилот, зочны зардал	2,187.0	7,682.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,434.6	4,526.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	131,541.0	311,229.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	453,524.3	18,159.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	322,336.3	507,205.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	203,150.6	285,975.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	203,150.6	285,975.2
2200	Дотоод эх үүсвэрээр	203,150.6	285,975.2
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-203,150.6	-285,975.2
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-100.0	-100.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЗЭЭЛ	100.0	100.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	119,085.7	221,129.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	327,560.2	446,645.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	446,645.9	667,775.7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,707,007.9	1,120,511.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	898,460.3	841,189.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	898,460.3	841,189.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	441,055.3	405,601.3
210101	Үндсэн цалин	338,672.1	288,565.9
210102	Нэмэгдэл	89,357.6	92,976.0
210104	Урамшуулал	13,025.6	24,059.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,132.1	55,132.1
210201	Тэтгэврийн даатгал	37,489.7	37,489.7
210202	Тэтгэмжийн даатгал	4,410.6	4,410.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,528.4	3,528.4
210204	Ажилгүйдлийн даатгал	882.2	882.2
210205	Эрүүл мэндийн даатгал	8,821.2	8,821.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	285,479.0	282,755.7
210301	Гэрэл, цахилгаан	20,434.5	17,450.4
210302	Түлш, халаалт	263,048.3	263,841.3
210303	Цэвэр, бохир ус	1,996.2	1,464.0
2104	Хангамж, бараа материалын зардал	38,597.9	38,573.0
210401	Бичиг хэрэг	7,848.4	7,654.1
210402	Тээвэр, шатахуун	26,517.5	26,517.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,232.0	3,401.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000.0	1,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,789.8	15,664.7
210604	Урсгал засвар	15,789.8	15,664.7
2107	Томилолт, зочны зардал	5,341.6	4,962.1
210702	Дотоод албан томилолт	5,341.6	4,962.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,989.7	4,526.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,460.0	4,331.5
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540.0	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	469.1	0.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227.7	61.7
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73.8	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203.4	133.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15.7	0.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,074.9	33,973.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	48,371.5	31,270.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,703.4	2,703.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	558,851.8	279,222.4
223001	Бусад хөрөнгө	558,851.8	279,222.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЗЭЭЛ	249,695.8	100.0
230001	Эргэж төлөгдөх зээл	249,695.8	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,707,007.9	1,241,566.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,198,812.7	1,223,587.4
320001	Орон нутгийн төсвөөс	879,214.4	903,989.1
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	319,598.3	319,598.3
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	508,195.2	17,978.7
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	17,978.7
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	508,195.2	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	106,994.8
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	228,049.4

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	30,687,987.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	30,687,987.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,127,336.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,360,861.08
210301	Гэрэл, цахилгаан	1,360,861.08
2104	Хангамж, бараа материалын зардал	397,000.00
210402	Тээвэр, шатахуун	260,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	117,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,720,000.00
210702	Дотоод албан томилолт	2,720,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,649,475.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,649,475.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	560,651.12
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	560,651.12
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	560,651.12
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	30,687,987.20
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,687,987.20
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	30,687,987.20

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Алдархаан сумын Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Эрхэм зорилго: Төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг оновчтой зохион байгуулж мэргэшсэн төрийн албан хаагчдаар төрийн албыг бүрдүүлэн иргэдэд төрийн үйлчилгээг ил тод шуурхай тэгш хүртээмжтэй хүргэхэд оршино.

Сумын хөгжлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 73 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж биелэлт 75.6 хувьтай байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Алдархаан сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай зэрэг хуулиудыг голлон мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алдархаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нутгийн захиргааны байгууллагууд нь нийтлэг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алдархаан сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 553,115.4 төгрөгөөр буюу 44.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	446,645.9	667,775.7	221,129.8
Авлага	214,658.0	196,679.3	(17,978.7)
Бараа материал	38,398.3	51,413.7	13,015.4
Үндсэн хөрөнгө	534,670.5	871,619.4	336,948.9
Нийт хөрөнгө	1,234,372.7	1,787,488.1	553,115.4
Өр төлбөр	8,754.3	3,041.6	(5,712.7)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,225,618.4	1,784,446.5	558,828.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,234,372.7	1,787,488.1	553,115.4

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 667,775.7 мянган төгрөг болж, өмнөх оноос мянган 221,129.8 төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төгрөг			
Төрийн сангийн харилцах	446,645.9	667,775.7	221,129.8
Дүн	446,645.9	667,775.7	221,129.8

Эх сурвалж: Алдархаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө өмнөх оны үлдэгдлээс 221,129.8 мянган төгрөгөөр өссөн нь сумын Засаг даргын Тамгын газрын ахмадын сангийн үлдэгдэл болон зарцуулаагүй үлдэгдлийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн, ОНХС-ийн зарим ажил хийгдээгүйгээс үлдэгдэл өссөн, мөн Хоршоо хөгжүүлэх сангийн авлага барагдаж үлдэгдэл 17,878.7 мянган төгрөгөөр өссөн зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Мөнгөн хөрөнгөтэй холбоотой зөрчил илрээгүй

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 196,679.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 17,978.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Хувь хүмүүсээс авах авлага	214,658.0	196,679.3	(17,978.7)
Дүн	214,658.0	196,679.3	(17,978.7)

Эх сурвалж: Алдархаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага өмнөх оны үлдэгдлээс 17,978.7 мянган төгрөгөөр буурсан нь Хоршоо хөгжүүлэх сангийн хувь хүмүүсээс авах авлага барагдсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Авлагатай холбоотой алдаа, зөрчил илрээгүй

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа данстай холбоотой үлдэгдэл тайланд тусгагдаагүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 51,413.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 13,015.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Хангамжийн материал	31,780.9	44,886.8	13,105.9
Бичиг хэргийн материал	703.6	2,291.2	1,587.6
Аж ахуйн материал	8,256.4	8,003.5	-252.9
Түлш, шатах тослох материал	0.0	6,158.8	6,158.8
Барилгын засварын материал	3.0	3.0	0.0
Бусад хангамжийн материал	22,817.9	28,430.3	5,612.4
Тусгай зориулалттай материал	6,617.5	6,527.0	(90.5)
Дүн	38,398.3	51,413.7	13,015.4

Эх сурвалж: Алдархаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны эцсийн үлдэгдэл 13,015.4 мянган төгрөгөөр өссөн нь ОНХС-ийн хөрөнгөөр 8,000.9 мянган төгрөгийн аж ахуйн материал бэлтгэж, данс бүртгэлд тусгасан, тайлант онд 55,481.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 48,864.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 1,602.5 мянган төгрөгийн бараа материал акталсан зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: ЗДТГ нь 3,648.4 мянган төгрөгийн бараа материалыг тодруулга тайлангаар дамжуулаагүй шууд зардлаар бүртгэсэн, 8,000.9 мянган төгрөгийн бараа материалыг данс бүртгэлд тусгаагүй орхигдуулсан зэрэг алдаа илэрсэнд залруулга хийсэн байна.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгөтэй холбоотой бүртгэл байхгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 871,619.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 336,948.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	504,071.8	841,590.7	337,518.9
Барилга, байгууламж, орон сууц	741,464.2	787,216.9	45,752.7
Авто-тээврийн хэрэгсэл	59,694.8	272,132.7	212,437.9
Машин тоног төхөөрөмж(компьютер)	270,488.2	401,068.4	130,580.2
Тавилга, аж ахуйн эд хогшил	34,065.8	45,065.8	11,000.0
Бусад үндсэн хөрөнгө	34,148.6	34,148.6	0.0
Ном	714.5	714.5	0.0
Биет бус хөрөнгө	30,598.7	30,028.7	(570.0)
Программ хангамж	3,802.0	3,802.0	0.0
Бусад биет бус хөрөнгө	29,221.2	29,221.2	0.0
Хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл	(638,928.8)	(701,750.7)	(62,821.9)
Дүн	534,670.5	871,619.4	336,948.9

Эх сурвалж: Алдархаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 336,948.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 6,752.7 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 230,580.2 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, бусад байгууллагаас 162,437.9 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авч, тайлант оны элэгдлийн зардалд 62,821.9 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: ЗДТГ нь Тайлант онд худалдаж авсан болон аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн хийгдсэн хөрөнгө оруулалтыг данс бүртгэлд тусгаагүй, үнэ төлбөргүйгээр шилжиж ирсэн 133,080.2 мянган төгрөгийн хөрөнгийг тайлант онд худалдаж авснаар бүртгэж, тайлагнасан зэрэг алдаа илэрсэнд залруулга хийсэн байна.

3.5.7 Өр төлбөр

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 3,041.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 5,712.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Өр төлбөрийн үлдэгдэл

<i>/мянган төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагад төлөх өглөг	1,123.7	698.1	(425.6)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	384.2	-	(384.2)
Ажилчидтай холбогдсон өглөг	7,246.4	2,343.5	(4,902.9)
Дүн	8,754.3	3,041.6	(5,712.7)

Өр төлбөр өмнөх оны үлдэгдлээс 5,712.7 мянган төгрөгөөр буурсан нь бараа үйлчилгээний зардлын өглөг 384.2 мянган төгрөг барагдсан, байгууллагад төлөх өглөг 425.6 мянган төгрөгөөр, ажиллагсадтай холбоотой өглөг 4,902.5 мянган төгрөгөөр барагдсан зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: ИТХ нь Нийгмийн даатгал, Татвартай тооцоо нийлж үүссэн өглөгийг данс бүртгэлд тусгаагүй алдаа илэрсэнд залруулга хийсэн байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,784,446.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 558,828.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

<i>/мянган төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	449,344.4	449,344.4	0.0
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	449,344.4	449,344.4	0.0
Хуримтлагдсан үр дүн	711,516.4	1,270,344.4	558,828.0
Өмнөх үеийн үр дүн	3,829,097.0	711,516.4	(3,117,581.0)
Тайлант үеийн үр дүн	-3,117,580.6	558,828.1	3,676,409.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	64,757.7	64,757.7	0.0
Дүн	1,225,618.5	1,784,446.5	558,828.0

Эх сурвалж: Алдархаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 558,828.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь шууд захирагчдын төсвийн төслийг нэгтгэдэггүй байна. Шууд захирагчид тус тусдаа төсвийн төслийг боловсруулан Төсвийн ерөнхийлөн захирагчийн холбогдох хэлтэст хүргүүлэн, нэгтгүүлж байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 06 дугаар тогтоолоор Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагыг 1,460,057.6 мянган төгрөгөөр баталжээ. Үүнээс орон нутгийн байгууллагын 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээ 1,228,527.4 мянган төгрөг байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр 308,646.6 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 248,913.4 мянган төгрөгийг аймгийн ОНХС-аас сумд олгох орлогын шилжүүлгээс, 231,530.2 мянган төгрөгийг Улсын төсөвт байгууллагуудын тогтмол зардалд орон нутгийн төсвөөс 222,422.0 мянган төгрөгийг татварын болон татварын бус орлогоос, 194,501.0 мянган төгрөгийг Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс 264,044.4 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс бүрдүүлэхээр сумын ИТХ-аар анх баталжээ.

Аймгийн 2023 оны төсвийн тодотголоор сумд олгох санхүүгийн дэмжлэгийг 76,895.5 мянган төгрөгөөр аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 70,684.9 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс олгох Улсын төсөвт байгууллагуудын тогтмол зардлыг 26,513.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 08 сарын 07-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг тодотгож, 1,706,559.9 мянган төгрөг болсон байна.

Гүйцэтгэлээр санхүүгийн дэмжлэгээс 383,542.1 мянган төгрөгийн, аймгийн ОНХС-с сумдад олгох шилжүүлгээс 319,598.3 мянган төгрөгийн, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 17,978.7 мянган төгрөгийн, татварын болон татварын бус орлогоос 235,179.0 мянган төгрөгийн, урьд оны үлдэгдлээс 26,710.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн нь батлагдсан төсвөөс 465,441.9 мянган төгрөг дутуу байна. Энэ нь аймгаас олгох санхүүгийн дэмжлэг 2,000.0 мянган төгрөгөөр дутуу олгогдсон, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орох орлогыг төлөвлөдөггүй, урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр тооцсон зэрэг нь нөлөөлж байна.

д/д	Санхүүгийн эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Санхүүгийн дэмжлэг	385,542.1	383,542.1	2,000.0
2	Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлэг	319,598.3	319,598.3	0.0
3	Татварын болон татварын бус орлого	235,179.0	235,179.0	0.0
4	Урьд оны үлдэгдэл	313,692.8	26,710.9	286,981.9
5	Үндсэн үйл ажиллагааны орлого	194,501.0	17,978.7	176,522.3
6	Улсын төсвийн байгууллагын тогтмол зардал	258,577.0	258,577.0	0.0
ДҮН		1,707,007.9	1,241,566.0	465,441.9

Татварын болон татварын бус орлогоор 402,033.8 мянган төгрөгийг бүрдүүлж, татварын буцаан олголтод 27,012.0 мянган төгрөгийг, санхүүжилтэд 235,179.0 мянган төгрөгийг олгож, 139,842.8 мянган төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд байршуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,120,511.5 мянган төгрөг буюу 65.6 хувьтай байгаа нь Засаг даргын нөөц хөрөнгийг хэмнэсэн, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан зарим ажил хийгдээгүй, Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгоогүй зэрэгтэй холбоотой байна.

Хүснэгт 8. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	120,893.4	120,513.5	379.9	99.7%
2	Засаг даргын Тамгын газар	519,302.9	464,716.9	54,586.0	89.5%
3	Орон нутгийн хөгжлийн сан	558,851.8	279,222.4	279,629.4	49.9%
4	Хоршоо хөгжүүлэх сан	249,695.8	100.0	249,595.8	0.04%
5	Улсын төсвийн байгууллагын тогтмол зардал	258,264.0	258,264.0	0.0	100%
ДҮН		1,707,007.9	1,120,511.5	586,496.4	65.6%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2023 онд нэмэлт санхүүжилтээр 30,688.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 30,127.3 мянган төгрөгийг цалин, тээвэр шатахуун, дотоод албан томилолт, бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулж, 560.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд хэрэгжсэн төсөл, хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Алдархаан сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Алдархаан сумын Засаг дарга нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдөр 1/43 дугаартай албан тоотоор ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,722,140.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 25,832.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 19,374.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, аудитыг гүйцэтгэх шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 20 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад шилэн дансны цахим системд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжтой холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Алдархаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй, зөвлөмж өгөгдөөгүй, дотоод хяналттай холбоотой 87,121.5 мянган төгрөгийн зөрчилд аймгийн Засаг даргад хариуцлага тооцох албан шаардлага өгч, хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	-	-	-	-	-
Хариуцлага тооцох албан шаардлага	1	179,295,5	1	179,295,5	100%
Нийт дүн	1	179,295,5	1	179,295,5	100%

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар дотоод хяналтыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой 250,346.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өглөө.

Аудитаар нийт илрүүлсэн 250,346.6 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 224,514.5 мянган төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй

5.2 Албан шаардлага

Төсвийн шууд захирагчдын аудитаар илэрсэн алдаа зөрчилд дүн шинжилгээ хийхэд сумын Орон нутгийн хөгжлийн сангийн болон Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой 250,346.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өглөө.

5.3 Зөвлөмж өгөгдөөгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	АТТ	Тоо	Дүн	
Орон нутгийн хөгжлийн сангийн болон Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлээгүй	1	250,346.6			1	250,346.6							
Дүн	1	250,346.6			1	250,346.6							

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Дүн										
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Дүн										
Нийт дүн										

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.БОЛДБААТАР

Огноо: 2024-03-25

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

Ц.ОЮУНСУВД

Огноо: 2024-03-25

